

**“АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ТӨГСГӨЛИЙН ШАТНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017оны 3 дугаар сарын 31

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл								
1.	“Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх” хөтөлбөр “ Засгийн газрын 2014-08-28-ний өдрийн 279 дүгээр тогтоол	Хөтөлбөрийн зорилго: Иргэдийн таатай амьдрах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай ахуйн үйлчилгээний цогцолбор төвүүдийн тоог нэмэгдүүлэн, үйлчилгээг ойртуулах, ажилгүйдлийг бууруулах, албан бус хөдөлмөр эрхлэлт, хөдөө орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг багасгахад хөтөлбөрийн зорилго оршино. Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах журам, санхүүгийн түрээсийн үйлчилгээний гэрээ, гурван талт гэрээний загваруудыг боловсруулж Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/221 тоот тушаалаар батлуулж хэрэгжүүлсэн.								
2.	<i>Санхүүжилтийн эх үүсвэр</i>	<ul style="list-style-type: none"> ➢ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан; ➢ Сум хөгжүүлэх сан; ➢ Зээлийн батлан даалтын сан; ➢ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан; ➢ Орон нутаг хөгжүүлэх сан. 								
3.	<i>Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа</i>	<ul style="list-style-type: none"> ➢ Ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн засаг захиргаа, үйлчилгээ эрхлэгчид <p>Хэрэгжих хугацаа: 2014-2016 Монгол Улсын нийт 21 аймаг, 330 сум. Ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүд.</p>								
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1.Төвүүдийг улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар бий болгох;</p> <p>Зорилт 2. Төр хувийн хэвшлийн түншлэлээр бий болсон ахуйн үйлчилгээний төвийн үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;</p> <p>Зорилт 3. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг зохистой албан хөдөлмөрт шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал санаачлагыг урамшуулах;</p> <p>Зорилт 4. Салбар дахь хүний нөөцийн хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.</p>								
5.	Зардал	<table border="1"> <tr> <td>Төсөв (Нийт шаардагдах зардал)</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Үүнд: тэрбум төгрөг</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </table>	Төсөв (Нийт шаардагдах зардал)				Үүнд: тэрбум төгрөг			
Төсөв (Нийт шаардагдах зардал)										
Үүнд: тэрбум төгрөг										
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт: Зорилт 1. <i>Төвүүдийг улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар бий болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:</i>	<p>1.1.хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг ашиглан ахуйн үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> ❖ Сумдад ахуйн үйлчилгээний цогцолбор төв байгуулах асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд улсын хэмжээнд шинээр байгуулагдах “Аймаг, сумын ахуйн үйлчилгээний цогцолбор төв”-үүдийн зураг төсөв гаргасан. ❖ Үндэсний хөгжлийн газраас ашиглаж болох, сэргээн засварлах шаардлагатай байрны судалгаа хийж ахуйн үйлчилгээний төвийн цогцолбор барилга барихад дараах: <ul style="list-style-type: none"> ➢ Архангай, Баянхонгор, Орхон, Дорнод, Хөвсгөл, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь, Хэнтий, Сүхбаатар зэрэг 10 аймгийн төвд шинээр барихад 30,0 тэрбум төгрөг, ➢ Ховд, Говь-Сүмбэр, Булган, Увс, Завхан, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар, Төв зэрэг 9 аймгийн төвд бэлэн болсон барилгыг худалдаж авахад 4.83 тэрбум төгрөг ➢ 109 суманд шинээр барихад 109.0 тэрбум, 								

		<ul style="list-style-type: none"> ➤ 73 суманд худалдаж авахад 8.73 сая төгрөг, ➤ 119 суманд сэргээн засварлахад 8.71 тэрбум төгрөг ➤ нийслэлийн 8 дүүрэгт шинээр барихад 24,0 тэрбум төгрөг, ➤ Сонгино хайрхан дүүрэгийн ахуй үйлчилгээний төвийг сэргээн засварлахад 1.15 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн урьдчилсан тооцоо гарсан байна. <p>Дээрхи төвүүдэд шаардлагатай санхүүжилтийг БНХАУ-ын Засгийн газраас олгож буй буцалтгүй тусламжийн үлдэгдэл хөрөнгөөр хэрэгжүүлэх саналыг 2014 онд Эдийн засгийн хөгжлийн яманд санал хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтцийн өөрчлөлтийн улмаас шийдэгдээгүй байна.</p> <p>❖ Засгийн газрын 2013-07-06-ний өдрийн 250 дугаар Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих тухай тогтоол гарсан. Чингэс бондын эх үүсвэрээс ҮХААЯ болон Хөдөлмөрийн яамны хооронд Дамжуулан зээлдүүлэх гэрээ, аймаг, нийслэлийн Боловсролын газар, үйлдвэрлэгч байгууллага, ЕБС-ын хооронд ажил гүйцэтгэх гурван талт 436 гэрээ мөн өдрүүдэд сурагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэгч тэргүүлэх 20 компани болон туслан гүйцэтгэгч үйлдвэрүүдтэй хамтын ажиллагааны гэрээ, түүнчлэн ҮХААЯ /тухайн үеийн/ болон үйлдвэрлэгчдийн хооронд зээлийн гэрээг 2013 оны 7 дугаар сард тус тус байгуулан ажилласан.</p> <p>❖ Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй оёдлын тэргүүлэх 7 компанид 9 тэрбум, ноосны 1 компанид 12 тэрбум, сүлжмэлийн 10 компанид 2.0 тэрбум, нийт 23.0 тэрбум төгрөгийн богино хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгосон байна.</p> <p>❖ Нийт 484.1 мянган ширхэг сурагчдын дүрэмт хувцас үйлдвэрлэхээр үндэсний оёдол, сүлжмэлийн 19 тэргүүлэх үйлдвэр болон туслан гүйцэтгэгч 125 жижиг, дунд оёдлын үйлдвэрт нийт 2632 хүн ажиллаж, ажлын байрыг 70 хувиар нэмэгдүүллээ.</p> <p>❖ 2014-06-01-ны байдлаар бага ангийн 185.9 мянган ширхэг, дунд ангийн 109.1 мян.ш ахлах ангийн 60.4 мян.ш хувцас үйлдвэрлэхээс нийт 86.2 хувийг үйлдвэрлэж, 10.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн. Зээлийн хүү болон үндсэн зээлийн эргэн төлөлт эхэлж 2.385.0 сая төгрөг орж ирсэн байна.</p> <p>❖ Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолынхэрэгжилтийг ханган ажиллах, сурагчийн дүрэмт хувцасны үйлдвэрлэлийг дотоодын үйлдвэрүүдээр үйлдвэрлүүлэх, өмнө зээл авсан аж ахуйн нэгжүүдийн зээл төлөлтийг хийлгэж дуусгуулах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хөдөлмөрийн яамны ТНБД-ын 2015-03-05-ны өдрийн 46 тоот “Зээлийн эргэн төлөлтийн талаар авах арга хэмжээний тухай” тушаалаар 900038401 тоот дансанд төлбөрийг төвлөрүүлэх, сурагчийн дүрэмт хувцасны төлбөр тооцоог тулгах, эргэн төлөлтөд хяналт тавьж ажилласнаар 2015-11-26-ны байдлаар 1999,5сая төгрөгийг төвлөрүүлэн Хөдөлмөр эрхлэх дэмжих санд 505,1 сая төг, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих санд 1999,06 сая төгрөгийг шилжүүлсэн байна. ➤ Мөн 2015-04-06-ны өдрийн 72 тоот тушаалаар Ажлын хэсэг байгуулан ажиллаж ээрмэлийн 6, даавууны 1, сүлжмэлийн 6, оёдлын 7, нийт 20 аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд шалгалт зээлийн эргэн төлөлтийг хийхгүй байгаа аж ахуй нэгжүүдийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргасан байна. ➤ 2016-11-31-ны байдлаар нийт 4 аж ахуйн нэгж 250,0 сая төгрөгийн төлбөрийг төлж, ЖДҮХС-д 236,6 сая төгрөг
--	--	---

		<p>дутуу төлөлттэй байна. Цаашид шүүхийн шийдвэр гарсан аж ахуйн нэгжийн шийдвэрийн гүйцэтгэлийг хангуулах дараагийн шатны арга хэмжээ авахуулах ажлыг зохион байгуулж ажиллана</p> <p>❖ Хүн амын олноор суурьшсан УБ, Дархан –Уул аймаг, Эрдэнэт хотуудад үйл ажиллагаа явуулж буй оёмол, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэрүүд кластраар хоршин ажиллаж, Монгол хонины ноосны орц бүхий даавуугаар дүрэмт хувцас үйлдвэрлэхэд зориулж “Сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэх үндэсний үйлдвэрийг дэмжих тухай” ЗГ-ын 2013 оны 250 дугаар тогтоолоор 23 тэрбум төгрөгийн зээлийг 18 аж ахуйн нэгжид олгож үйлдвэрлэлийг явуулахад дэмжсэнээр нийт 2500 гаруй ажлын байр нэмэгдэж, дүрэмт хувцасны үйлдвэрлэлд оролцсон. Үүний үр дүнд Монгол хонины ноосон даавуугаар хийсэн дүрэмт хувцасаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдийн 90 орчим хувийг хангасан бөгөөд нийт сурагчид нэгдсэн загварын дүрэмт хувцас өмсөх боломж бүрдсэн.</p> <p>❖ 2016-2017 оны хичээлийн жилд 551,9 мянган суралцагч суралцаж байна. Бага ангид 288.3, дунд ангид 167.3, ахлах ангид 96.2 мянган суралцагч суралцаж байна. Дүрэмт хувцасны үндсэн хувцасаар нийт суралцагчдын 73,4% хамрагдсан байна. Үүнээс: эрэгтэй суралцагчдын 68,6% нь хүрэм, өмдөөр хангагдсан бол эмэгтэй сурагчдын 78,2% нь сарафан цэнхэр цамцаар хангагдсан байна.</p> <p>❖ Засгийн газраас ахуй үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж байгууллагуудын бүтээгдэхүүнийг борлуулах, сурталчилах зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалааг удаа дараа зохион байгуулан ажиллав. Үүнд:</p> <p>❖ Баянхонгор аймаг нь ӨМӨЗО-ны Альшаа аймаг, Цэхээ хилийн боомттой хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2016-01-13-20-н хүртэл хугацаанд “Цагаан сар” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж ажиллалаа. Үзэсгэлэн худалдаанд Баянхонгор, Галуут, Эрдэнэцогт, Баян-өндөр, Шинэжинст, Богд, Жинст, Баянговь, Баянлиг, Өлзийт, Бууцагаан зэрэг сумдын 127 бизнес эрхлэгч оролцсон. Үзэсгэлэн худалдаанд 11 сумын 127 иргэн, аж ахуй нэгж байгууллага мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн, чацаргана, цэвэр ус, модон эдлэл, үндэсний хувцас, гар урлал гэх мэт 6 нэр төрлийн 90 гаруй бүтээгдэхүүнээр оролцож, нийтдээ 280,0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ:100</p> <p>1.2.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ахуйн үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>❖ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол ажлын хүрээнд улсын төсвөөс 2014, 2015 онуудад нийт 3.347 тэрбум төгрөг гаргаж 27 суманд шинээр Ахуйн үйлчилгээний төв байгуулсан байна. 27 ахуйн үйлчилгээний төвийн 15 байр нь шинээр баригдсан ба үлдсэн 12 төвийн байрыг улсын өмчийн ашиглагдахгүй байгаа байрыг засварлан шинэчилсэн байна.</p> <p>❖ Засгийн газрын 2014 оны 279 тоотогтоолоор “Ахуй үйлчилгээний хөтөлбөр”-ийг баталж Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ахуйн үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2014 онд шинээр 138 суманд орон нутгийн өмчийн ашиглагдаагүй барилгыг ахуйн үйлчилгээний төвийн зориулалтаар ашиглаж эхэлсэн. Хөтөлбөрийн хүрээнд оёдол, гутал, фото зураг, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар, үсчин гоо сайханы чиглэлээр дээрх төвүүдэд 1080 шинэ ажлын байр бий</p>
--	--	--

	<p>болсон байна.</p> <p>❖ 2015 оны ЖДҮХС-гийн хөнгөлөлттэй зээлээс ахуйн үйлчилгээний 4 төсөлд 210 сая, гоо сайхны 4 төсөлд 446.0 сая, халуун усны 2 төсөлд 35.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн.</p> <p>❖ Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр байгуулсан Ахуйн үйлчилгээний төвүүдийн ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг сайжруулах зорилгоор 17 аймгийн 56 сумын 336 үйлчилгээ эрхлэгчдэд мэргэжил дээшлүүлэх сургалтыг Монголын үйлдвэрлэлийн хоршоодын төв холбоотой хамтран зохион байгуулсан. Үүнд:</p> <p>Архангай аймаг: 2014 онд Чулуут суманд улсын төсвийн хөрөнгө оруулалт 1262 мянга төгрөгөөр барьж, Эрдэнэбулган суманд 650 сая төгрөгөөр “Ахуй үйлчилгээ бизнес инкубатор төв”-ийг барьсан байна. Төв байгуулагдснаар нийт 478 хүн тогтмол ажлын байртай болж 9 суманд 180.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг олгогдсон. Нийт 252 иргэнийг сургалтанд хамруулж 9560.0 мянган төгрөгийг санхүүжилтэнд зарцуулсан.</p> <p>Баян-Өлгий аймаг: 2 сумд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ахуй үйлчилгээний жижиг төв 45,0 сая төгрөгөөр шинээр баригдсан. Ахуйн үйлчилгээний чиглэлийн хөдөлмөр эрхлэгчдэд СХС-аас 245 иргэнд, ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас 40 иргэнд, ХЭДС-аас 45 иргэнд, нийт 330 төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлэн, 354 шинэ ажлын байрыг бий болгосон</p> <p>Булган аймаг: Нийт 7 сум <u>1136.0 сая</u> төгрөгийн хөрөнгөөр ахуйн үйлчилгээний төв байгуулж ажлын байр бий болгож, ахуйн үйлчилгээ эрхлэлтийг дэмжиж сум хөгжүүлэх сангаас <u>63 иргэнд 674.9 сая</u> төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. 3000-5000 хүртэл хүн амтай ахуйн үйлчилгээний байртай Баян-Агт, Орхон, Сайхан, Тэшиг, Хангал суманд ахуйн үйлчилгээ эрхлэгчидээ сургалтад хамруулж Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрээс 135,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр олгосон.</p> <p>Дархан аймаг: Нийт 43 төсөлд 64,5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон, 19 төсөлд 21 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Мэргэжил олгох сургалтанд нийт 130 иргэн хамрагдаж 17.9 сая төгрөг зарцуулсан. Хонгор, Орхон сумдын орон нутгийн хөгжлийн сангаар засварлагдсан байрыг ахуйн үйлчилгээний чиглэлээр ашиглаж байна.</p> <p>Дорнод аймаг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 18 иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Байр түрээслэн үсчин гоо сайхны үйлчилгээ үзүүлдэг 6 иргэнийг 600,0 мян төгрөг, Булган суманд цэцэрлэгийн хуучин барилгыг орон нутгийн хөгжлийн сангаас 2015 онд 60.0 сая төгрөгөөр засч тохижуулан ахуйн үйлчилгээний төв болгон ,2016 онд 38.0 сая төгрөгөөр нам даралтын тогоо суурилуулж халаалтын асуудлыг шийдвэрлэсэн. “Ахуйн үйлчилгээ-2016” сарын аян зохион байгуулахад аймгийн ЗДТГ-аас 1100.0 мян төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Нийт 150 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>Дорноговь аймаг: Аймгийн хэмжээнд ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэдийг орон нутгаас дэмжин “Сум хөгжүүлэх сан”-гийн хөнгөлөлттэй зээлд 32 төсөл шалгаруулан нийт 170.3 сая, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хөгжлийн бэрхшээлтэй 27 иргэнд 29.1 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Нийт 31 бойжигч, 187 иргэнд энэ чиглэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна</p> <p>Хэнтий аймаг: 298 сая төгрөг орон нутгийн хөгжлийн сангаас</p>
--	--

гарч Хэрлэн, Буянхутагт сумдад ахуй үйлчилгээний төв байгуулсан. Мөн 5 суманд 150 сая төгрөг зарцуулан ашиглагдахгүй байгаа байрыг засч үйлчилгээний төвтэй болгож /7 аймаг ахуйн үйлчилгээний төвтэй болсон./нийт 95.8 сая төгрөгийн ахуй үйлчилгээний тоног төхөөрөмж олгосон.

Сүхбаатар аймаг: Нийт 46 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг “Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон байна. 23 иргэнд гар урлалын чиглэлээр сургалт зохион байгуулж сургалтын зардалд 3680,0 сая төгрөг мөн оёдол, үсчиний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 иргэнийг хамруулж 520 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Говь-Алтай: Аймгийн хэмжээнд нийт 128 төсөлд 409 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож 46 төсөлд 36,6 сая төгрөгийн буцалтгүй тусламж тус тус олгосон байна. Мөн 91 иргэнийг сургалтанд хамруулж мэргэжил олгох, мэргэшүүлэх ажлыг хэрэгжүүлсэн.

Орхон аймаг. 2016 онд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 11484,0 мян/төгрөг зарцуулсан. 2014-2015 онд Жаргалант сумд 100 сая төгрөгөөр Ашиглагдахгүй байгаа халуун усны төвийг засварлан ашиглалтад оруулсан.

Сэлэнгэ аймаг: 2014-2016 онд 78 ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг 99.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт, 30 иргэнийг 135.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамрууллаа. Үүний үр дүнд 145 ажлын байр шинээр бий болж, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, үйлчилгээнийхээ хэмжээг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Төв аймаг. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуучин барилга засварлах, шинээр барихад нийт 6 суманд 270,8 сая төгрөгийн зарцуулсан. Нийт 38 иргэнийг 334,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулснаар 83 шинэ ажлын байр бий болсон. 12 суманд 215,0 сая төгрөгийн 36-н нэр төрлийн 452 ширхэг тоног төхөөрөмжийн зээлд хамруулсан.

Увс аймаг. 73,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан өгч, 28 шинэ ажлын байр бий болгосон. Аймгийн ЖДҮ сангаас 5 иргэнд 86 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон.

Завхан аймаг. 15 суманд 261.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, 106 хүнийг ажлын байраар хангасан. Мөн 5 суманд 175 сая төгрөг зарцуулж, ашиглагдахгүй байгаа байрыг засч ахуй үйлчилгээний төв болгосон.

❖ Аж үйлдвэрийн яам 2015 онд Ховд аймгийн Жаргалант суманд 761,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ахуйн үйлчилгээний төвийн барилгад улсын төсвөөс 2015 онд 217,7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 97 тоот тушаалаар орон нутагт нь эрхийг шилжүүлсэн байна.

Ахуй үйлчилгээний барилга 2014-2016 он

Шинээр барьсан	Шинээр барилга барьсан	15
	Зориулалтыг өөрчилж шинэчилсэн	12
Засварласан	Ашиглаж байгаа барилга	66
	Ашиглагдахгүй байгаа барилга	40
Бүгд		133


Мэдээллийн эх үүсвэр: Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

❖ “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг 21 аймаг тус бүр боловсруулан хэрэгжүүлж ажилласан. Үндсэн хөтөлбөр болон дэд хөтөлбөрийн хүрээнд 21 аймгийн Орон нутаг хөгжүүлэх сангаас 116 “Ахуйн үйлчилгээний төв”-ийг шинэчлэн

засварлахаар нийт 3.006 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд үүний үр дүнд 7 аймгийн 40 сумдын 40 ахуйн үйлчилгээний байр шинээр бий болж 11 аймгийн 66 сумдад 66 ахуйн үйлчилгээний төвд засвар хийгдэж иргэдэд үйлчлэх, үйл ажиллагаа явуулах тав тухтай Ахуйн үйлчилгээний төвтэй болсон байна.

❖ 2016 оны төсвийн төсөөлөлд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санал орсон боловч Засгийн газрын бүтцийн өөрчлөлтийн улмаас ахуйн үйлчилгээний салбарын асуудал хариуцах эзэнгүй орхигдсоноос төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй болно.

2013-2016 оны байдлаар



❖ 2014 онд “Ахуйн үйлчилгээний салбарт” мөрдөгдөж буй стандартыг шинэчлэх, шинээр боловсруулах зорилгоор стандартчлалын улсын үзлэгийг зохион байгуулж салбарт үйл ажиллагаа явуулж буй 16 төрөлд үзлэг хийхэд одоо мөрдөгдөж буй 8 төрлийн стандартыг бүхэлд нь шинэчлэх хэрэгтэй, мөн шинээр 8 стандарт боловсруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарч тус ажлын хүрээнд айл гэр албан байгууллага нүүлгэх үйлчилгээний стандартыг боловсруулах ажлын хэсэг байгуулсан боловч ЗГ-ын бүтцийн өөрчлөлт хийгдсэний улмаас 2 жилийн хугацаанд 2 яам дамжин стандарт боловсруулагдаагүй байна.

❖ 2016 оны 11 дүгээр сард шинэчлэх болон шинээр боловсруулах стандартын жагсаалтыг гаргаж Стандарт хэмжилзүйн газарт хүсэлт хүргүүлж 2017 онд 2 стандарт шинээр боловсруулах, 2 стандартыг шинэчлэхээр төлөвлөгөөнд оруулан ажилласан.

Үнэлгээ:100

1.3. явуулын ахуйн үйлчилгээний хэлбэрийг дэмжих.

❖ Явуулын ахуйн үйлчилгээний хэлбэрийг хэрэгжүүлэх зорилгоор 2014 онд 5 аймгийн (Булган, Архангай, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай) 28 сумын сум бүрт 4 хоног ажиллаж нийт 2.4 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн хөрөнгөөс гарган явуулын ахуй үйлчилгээний үйл ажиллагаа явуулах ажлыг зохион байгуулсан.

❖ 2016 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар “Ахуйн үйлчилгээ-2016” дэд хөтөлбөр боловсруулаж алслагдсан сумдад “Явуулын ахуйн үйлчилгээ”-г 8 төрлийн үйлчилгээгээр мэргэжлийн холбоодтой хамтран Халхгол, Матад, Чулуунхороот, Гурванзагал сумдын иргэдэд хүргэн үйлчилгээ үзүүлж байна.

❖ Эдийн засгийн хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан 2013 оны 17, А/32, 38, А/30 дугаар тушаалын хүрээнд “Сум төсөл”-д ажлын хэсэг гарган ажиллаж 21 аймаг, 9 дүүрэгт байгуулах бизнес инкубатор төвүүдийн судалгааг хийсэн ба уг судалгаагаар сумын хүн амын тооноос хамааруулан (ө.х аймгийн төв, 5000-аас дээш хүн амтай сум, 3000-5000 хүн амтай сум, 3000 хүртэлх хүн амтай сум) ангилан, ангилал тус бүрд баригдах “Ахуйн үйлчилгээний төв”, “Бизнес инкубатор төв”, “Ахуйн үйлчилгээ, бизнесийг дэмжих төв”-ийн зураг төсвийг хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, бизнес инкубаторыг аймаг бүрт

		<p>байгуулахаар 2014-2018 оны хөрөнгө оруулалтын төсөлд саналаа тусган ажиллаж байна.</p> <p>❖ Дэрхи хамтарсан тушаалын хүрээнд “Сум төсөл”-д ажлын хэсэг байгуулж 21 аймаг, 330 суманд одоо үйл ажиллагаа явуулж байгаа болон цаашид шаардлагатай үйлдвэрийн судалгааг хийсэн ба судалгааны дүнгээр 16523 үйлдвэр шинээр байгуулах шаардлагатай гэсэн тооцоо гарсан. Ажлын хэсэг судалгаандаа үндэслэн аймаг, сумын хүн амын тооноос хамааруулан “Ахуйн үйлчилгээний төв”, “Бизнес инкубатор төв”, “Ахуйн үйлчилгээ, бизнесийг дэмжих төв”-ийн Техник эдийн засгийн үндэслэл хийх зургийн даалгаврыг боловсруулж зураг төслийн компаниудаар зураг төсвийг хийлгэсэн боловч санхүүжилтгүй улмаас баригдаагүй байна.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ: 70</p>																														
1-р зорилтын дундаж үнэлгээ: 90,0																																
	<p>Зорилт-2.Төвүүдийг улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар бий болгох зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:</p>	<p>2.1.тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ (лизинг)-нд хамруулах; хөнгөлөлттэй зээлд хамруулах</p> <p>❖ Хөдөлмөрийн сайдын 2014-10-29-ний өдрийн А/221 тоот тушаалаар 21 аймагт 138 сумдад Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр нийт 2,4 тэрбум төгрөгийн оёдлын машин, хэрээсний машин, зургийн аппарат, гар утас болон ахуйн электрон барааны засварын багаж хэрэгсэл зэрэг ахуйн үйлчилгээний зориулалтын тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн үйлчилгээний хэлбэрээр олгосон. Тоног төхөөрөмж худалдан авч үйлчилгээ эрхлэгчдэд олгох үйл ажиллагааг Хөдөлмөрийн сайдын 2014-03-19-ний А/44 тоот тушаалаар баталсан 21 аймаг тус бүрийн Жижиг дунд үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах дэд комисс сонгон шалгаруулалт хийж тоног төхөөрөмжийн лизингийг 3 жилийн хугацаатай жилийн 5%-ийн хүүтэй олгосон байна</p> <p>❖ Сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэх үндэсний үйлдвэрийг дэмжих тухай” Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолыг батлуулан 23 тэрбум төгрөгийн зээлийг 18 аж ахуйн нэгжид олгосон. Сурагчийн дүрэмт хувцасны Эмэгтэй иж бүрдэл 62.5 мян.ш, Эрэгтэй иж бүрдэл 59.6 мян.ш , Даавуун цамц 43.5 мян.ширхэгийг тус тус борлуулж, нийт борлуулалт Улаанбаатар хотод 1 954.6 сая төгрөг, орон нутагт оёмол иж бүрдэл хувцас 4.8 тэрбум , бүгд 6.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ: 70</p> <p>2.2.зээлийн батлан даалтын үйлчилгээнд хамруулах.</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрэрхлэлтийгдэмжих, иргэдийн орлогын тогтвортой эхүүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоох Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг 2012-02-10-нд баталсан. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2012-11-06-нд Зээлийн батлан даалтын сан байгуулагдаж, 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 5 тэрбум төгрөгийн эх үүсвэр батлагдсан.</p> <p style="text-align: center;"><i>Гаргасан батлан даалт үйл ажиллагааны салбараар</i></p> <table border="1" data-bbox="628 1890 1489 2116"> <thead> <tr> <th>Үйл ажиллагааны салбар</th> <th>Зээлдэгчийн тоо</th> <th>Олгосон зээл</th> <th>Гаргасан батлан даалт / сая төг./</th> <th>Батлан даалтын эзлэх хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Үйлдвэрлэл</td> <td>227</td> <td>48,137.01</td> <td>19,230.92</td> <td>49.91</td> </tr> <tr> <td>Үйлчилгээ</td> <td>59</td> <td>17,028.00</td> <td>6,952.42</td> <td>18.26</td> </tr> <tr> <td>Худалдаа</td> <td>96</td> <td>16,041.69</td> <td>6,643.04</td> <td>17.58</td> </tr> <tr> <td>Хөдөө аж ахуй</td> <td>57</td> <td>10,299.60</td> <td>4,925.77</td> <td>14.25</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>439</td> <td>91,506.30</td> <td>37,752.15</td> <td>100.</td> </tr> </tbody> </table>	Үйл ажиллагааны салбар	Зээлдэгчийн тоо	Олгосон зээл	Гаргасан батлан даалт / сая төг./	Батлан даалтын эзлэх хувь	Үйлдвэрлэл	227	48,137.01	19,230.92	49.91	Үйлчилгээ	59	17,028.00	6,952.42	18.26	Худалдаа	96	16,041.69	6,643.04	17.58	Хөдөө аж ахуй	57	10,299.60	4,925.77	14.25	Нийт	439	91,506.30	37,752.15	100.
Үйл ажиллагааны салбар	Зээлдэгчийн тоо	Олгосон зээл	Гаргасан батлан даалт / сая төг./	Батлан даалтын эзлэх хувь																												
Үйлдвэрлэл	227	48,137.01	19,230.92	49.91																												
Үйлчилгээ	59	17,028.00	6,952.42	18.26																												
Худалдаа	96	16,041.69	6,643.04	17.58																												
Хөдөө аж ахуй	57	10,299.60	4,925.77	14.25																												
Нийт	439	91,506.30	37,752.15	100.																												

➤ Зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2014-2016 оны хооронд 21 аймгаас зөвхөн 4 аймгийн 11 төсөлд нийт 80,5 сая төгрөгийн хүсэлт ирүүлснээс 66 сая төгрөгт батлан даалт хийгдсэн байна.

Үнэлгээ: 90

2.3.хөнгөлөлттэй зээлд хамруулах;

❖ “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2014-2016 оны хооронд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлд 21 аймгийн 109 төсөлд 3.522 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна. Үүнээс 2014 онд нийт 64 иргэн, аж ахуй нэгжид 2.995 тэрбум төгрөгийг жилийн 7% хүүтэй 5 жилийн хугацаатай олгосон байна.

Ахуй үйлчилгээний салбар үзүүлсэн дэмжлэг, зээл 2014-2016

Санхүүжилтийн эх үүсвэр	Иргэн, ААН, тоо	Дун (сая.төг)
Улсын төсөв	27	3347
ЖДҮХСан	109	7644
Сум хөгжүүлэх сан	525	3006
Орон нутгийг хөгжүүлэх сан	116	1894.7
Тоног төхөөрөмжийн Лизинг	27	268.1
Зээлийн батландаалтын сан	11	80.5
Хөдөлмөр эрхлэлтийн сан	594	794.66
Түрээсийн хөнгөлөлт	138	989.11

Мэдээллийн эх үүсвэр: Жижиг дунд, үйлдвэрийг хөгжүүлэх сан

❖ 2015, 2016 онуудад нийт 45 иргэн, аж ахуй нэгжид 527 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг жилийн 9% хүүтэй 5 жилийн хугацаатай олгосон байна. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгогдсон зээлийн хүрээнд нийт 424 ажлын байр хадгалагдан үлдэж шинээр 437 ажлын байр бий болсон байна. Зээлд хамрагдсан 109 иргэн, аж ахуй нэгж байгууллагаас 55 аж ахуй нэгж байгууллага нь шинээр байгуулагдан ахуйн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж эхэлсэн бол 54 нь үйл ажиллагаагаа өргөтгөсөн байна.

❖ Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийхэд ахуйн үйлчилгээний зориулалтаар олгосон зээлд ямар нэгэн зөрчил илрээгүй, бүгд авсан зээлийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

❖ Орхон аймгийн Жаргалант суманд Сум хөгжүүлэх сангаас олгосон 100 сая төгрөгөөр ашиглагдахгүй байгаа улсын өмчийн байрыг засварлан зочид буудал, үсчин, оёдолчин, халуун усны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тохижуулсан боловч газар зүйн байршилаас шалтгаалан чийгшил үүсч мөөгөнцөрдсөний улмаас одоог хүртэл ашиглаагүй байна.

❖ НҮБ-ын Хөдөө аж ахуйн төслийн хүрээнд болон бусад томоохон компаниудын дэмжлэгтэйгээр Дархан-Уул аймгийн 10 иргэнд 37 сая төгрөг, бусад компаниудын дэмжлэгтэйгээр Сэлэнгэ, Төв аймгуудын 66 компанид 337,9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2010-2016 онд олгосон зээл /үйлдвэрлэлийн чиглэлээр/

Чиглэл	Төслийн тоо	Зээл /сая.төг/	Үйл ажиллагаа		Ажлын байр	
			Өргөтгөсөн	шинээр	шинэ	хадгалсан
Хүнсний үйлдвэр	563	64572.70	95	11	3685	3481
Хөнгөн	1,122	73027.88	179	4	4659	4960
Газар тариалан	550	34033.72	87	29	2114	1807

Мал аж ахуй	668	40866.26	90	28	2618	1606
Барилгын үйлдвэрлэл	341	60462.75	79	12	3705	2241
Зоорь	83	21295.64	3	12	340	287
Био	29	6412.50	8	1	250	229
Худалдаа, үйлчилгээ	575	31260.30	57	23	3209	1994
Бусад	306	36811.18	70	37	1951	1765
Боловсруул ах үйлдвэр	15	9280.50	12	3	92	132
Дахивар	2	580.00	2	-	54	35
Нийт	4254	378603.42	682	160	22677	18537

Мэдээллийн эх үүсвэр: Жижиг дунд, үйлдвэрийг хөгжүүлэх сан

Үнэлгээ: 100

2- зорилтын дундаж үнэлгээ: 86,6

<p>Зорилт-3. Албан бус хөдөлмөр эрхлэлтээс зохистой албан хөдөлмөрт шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал, санаачилгыг урамшуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:</p>	<p>3.1.Албан бус хөдөлмөр эрхлэлтээс зохистой албан хөдөлмөр эрхлэлтэд шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 6 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг 1 удаа олгох.</p> <p>❖ Албан бус хөдөлмөр эрхлэлтээс зохистой албан хөдөлмөр эрхлэлтэд шилжин орох ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг ажлын байраар хангаж байгаа ААН-д урамшуулал олгох зорилтын хүрээнд 2 аймгийн нийт 8 ажил олгогч аж ахуйн нэгжид нийт 11,41 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Үүнд Төв аймагт Оёдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг БОНН ХХК ажил олгогчийн дэмжлэг урамшуулал 4,6 сая төгрөг болон Дархан аймагт 3 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 2 ААН, байгууллагын гэрээг дүгнэж 6,91 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.</p> <p>❖ Бүх аймгаас урамшуулалд хамрагдахаар хүсэлт ирүүлж нийт 57 компани 94 ажлын байр бий болгосон хэдий ч санхүүжилтгүй, тухайн жилийн төсөвт тусгагдаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийг тасралтгүй төлөх шаардлагыг хангаагүй зэрэг шалтгаануудаас урамшуулалд хамрагдаж чадаагүй байна.</p> <p>Үнэлгээ: 70</p>
<p>Зорилт 4. Салбар дахь хүний нөөцийн хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:</p>	<p>4.1.ахуйн үйлчилгээний салбарт ажиллагчдыг мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах;</p> <p>❖ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Орон нутаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс “Ахуйн үйлчилгээний салбар”-т ажиллагсадад мэргэжлийн ур чадвар олгох, мэдлэгийг нь дээшлүүлэх зорилгоор 21 аймагт оёдол, гэрэл зураг, үсчин, гоо сайхан, мужаан, ахуйн электрон засвар, гар утас засвар, мушаан, гагнуурчин зэрэг үйлчилгээнүүдээр 3486 иргэнд нийт 49,6 сая төгрөгөөр сургалт семинар зохион байгуулж улмаар 431 иргэнийг ажлын байртай болгож 3055 иргэн мэргэжлээ дээшлүүлэн ахуйн үйлчилгээний салбарт ажиллаж байна.</p> <p>❖ Мөн 2 жил тутамд “Монголын үсчин гоо засалчдын холбоо” ТББ-ын зохион байгуулдаг “Улсын үсчин гоо засалчдын аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2014 онд 7 сая төгрөгөөр дэмжин 21 аймгаас 19-аймагт (Баян-Өлгий, Ховд аймгууд оролцоогүй) “Аймгийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг зохион байгуулж улмаар аймаг дүүргийн аваргуудыг оролцуулан “Улсын үсчин, гоо засалчдын аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2014 оны 11 дүгээр сард “Улсын Цирк”-д зохион байгуулсан.</p> <p>❖ Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэмжлэгтэйгээр 2016-12-05-нд “Улсын үсчин, гоо засалчдын аварга шалгаруулах тэмцээн”-ийг 20 аймгийг (Баян-Өлгий</p>

оролцоогүй) оролцуулан амжилттай зохион байгуулсан.

❖ Улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт үзүүлсэн оролцогчид бүс нутаг, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд өөрийн болон ТББ-ын дэмжлэгтэйгээр амжилттай оролцож салбарын хөгжилийг бодитоор харуулсаар байна. Үүнд: 2016 оны БНСУ-д зохион байгуулагдсан дэлхийн үсчин гоо засалчдын аварга шалгаруулах “HAIRWORLD 2017” тэмцээнээс Мастер үсчин “Алтан медаль хүртсэн байна.

❖ Монголын үйлдвэрлэлийн хоршоодын төв холбоотой хамтран Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр байгуулсан Ахуйн үйлчилгээний төвүүдийн ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг сайжруулах зорилгоор 17 аймгийн 56 сумын 336 үйлчилгээ эрхлэгчдэд мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулав.

❖ Монголын гуталчдын холбоотой хамтран хөдөө орон нутагт ахуйн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулж Өвөрхангай, Архангай, Булган, Завхан аймгуудын 20 гаруй сумдын иргэдэд үйлчилгээг хүргэлээ.



Эх үүсвэр: Яамны web хуудас

Үнэлгээ: 90

4.2. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бизнес, менежментийн сургалтад хамруулах;

➤ Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний ажилтны тэмдэглэн өнгөрүүлэх” ажлын хүрээнд “Ахуйн үйлчилгээний салбарын Залуучуудын чуулга уулзалт”-ыг 2015-10-31-ээс 2015-11-01 өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Уулзалтын хүрээнд салбарын талаар төрөөс баримталж буй бодлого болон үйлчилгээний салбарын статистик, стандарт, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар мэдээлэл хийсний зэрэгцээ нийслэлд үйл ажиллагаа явуулж буй жишиг болохуйц үйлчилгээний салон, цэгүүдийг үзэж туршлага солилцох аялыг зохион байгууллаа. Чуулга уулзалтад аймаг нийслэлийн 200 орчим төлөөлөгчид оролцсон.

➤ Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбоо” ТББ 2016-10-04-нд ““Ахуйн үйлчилгээний салбар үүсч хөгсний 85 жил”-ийн ойн баярын тохиолдуулан 21 аймгийн салбарын төлөөллүүдийн хэлэлцүүлэг зөвлөгөөнийг ТББ, салбарын ААН, байгууллагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан.

Үнэлгээ: 50

4.3. мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд нарийн мэргэжлийн ажилчин сургаж бэлтгэх, залгамж чанарыг хадгалах.

❖ Орон нутгийн хөгжлийн сангаас 2014, 2015 ондуудад 21 аймагт сумдын төлөөллүүдийг оролцуулан нийт 51,4 сая төгрөгийн санхүүжүүлт хийж Монгол-Солонгосын коллеж, Монголын Хөдөлмөрийн Биржүүдийн нэгдсэн холбоотой хамтран үсчин-264, хүнд машин механизмын оператор-61, тогооч-415, барилгын цахилгаанчин-82, гагнуурчин-357, оёдол эсгүүр-510, хүүхэд асрагч-125, гутал засварчин-215, ахуйн бараа болон гар

		<p>утас засварчин-185, мушаан-196 зэрэг мэргэжлүүдээр нийт 2410 иргэнд шинээр мэргэжил олгосон байна. Үүнээс мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалт болон шинээр эзэмшүүлэх, үйлдвэрлэлийн нарийн мэргэжлийн сургалтуудад хамрагдан давхардсан тоогоор 3055 ажилчид ахуйн үйлчилгээний салбарт шинээр мэргэшин ажиллаж байна.</p> <p style="text-align: center;"><i>Сургалтанд хамрагдсан байдал 2014-2016 он</i></p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Мэргэжлийн чиглэл</th> <th>Хамрагдсдын тоо</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td>Үсчин</td> <td>264</td> </tr> <tr> <td></td> <td>Хүнд машин механизмын оператор</td> <td>61</td> </tr> <tr> <td></td> <td>Тогооч</td> <td>415</td> </tr> <tr> <td></td> <td>Барилгын цахилгаанчин</td> <td>82</td> </tr> <tr> <td></td> <td>Гагнуурчин</td> <td>357</td> </tr> <tr> <td></td> <td>Оёдол эсгүүр</td> <td>510</td> </tr> <tr> <td></td> <td>Хүүхэд асрагч</td> <td>125</td> </tr> <tr> <td></td> <td>Гутал засварчин</td> <td>215</td> </tr> <tr> <td></td> <td>Ахуйн бараа болон гар утас засварчин</td> <td>185</td> </tr> <tr> <td></td> <td>Мужаан</td> <td>196</td> </tr> <tr> <td></td> <td>Нийт</td> <td>2410</td> </tr> </tbody> </table> <p><i>Мэдээллийн эх үүсвэр: Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</i></p> <p style="text-align: right;">Үнэлгээ:90.</p>	№	Мэргэжлийн чиглэл	Хамрагдсдын тоо		Үсчин	264		Хүнд машин механизмын оператор	61		Тогооч	415		Барилгын цахилгаанчин	82		Гагнуурчин	357		Оёдол эсгүүр	510		Хүүхэд асрагч	125		Гутал засварчин	215		Ахуйн бараа болон гар утас засварчин	185		Мужаан	196		Нийт	2410
№	Мэргэжлийн чиглэл	Хамрагдсдын тоо																																				
	Үсчин	264																																				
	Хүнд машин механизмын оператор	61																																				
	Тогооч	415																																				
	Барилгын цахилгаанчин	82																																				
	Гагнуурчин	357																																				
	Оёдол эсгүүр	510																																				
	Хүүхэд асрагч	125																																				
	Гутал засварчин	215																																				
	Ахуйн бараа болон гар утас засварчин	185																																				
	Мужаан	196																																				
	Нийт	2410																																				
4- дүгээр зорилтын дундаж үнэлгээ: 76,6																																						
7.	<p>Дүгнэлт: (ололт, дутагдал, асуудал) анхаарах</p>	<p>➤ “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр” 2014-2016 –ийн хүрээнд Хөдөлмөрийн сайдын 2014-10- 29-ний А/221 тоот тушаалаар баталсан нийт 12 тэрбум төгрөгний санхүүжилтээс нийт 6353 сая төгрөгийн санхүүжилт олгогдож улсын 21 аймгийн хэмжээнд 67 сумдад 67 “Ахуйн үйлчилгээний төв” шинээр бий болж 66 сумын төвийн 66 “Ахуйн үйлчилгээний төв”-ийн барилгыг засварлан шинэчилж үйл ажиллагаа эрхлэх тав тухтай орчинг бүрдүүлж, иргэдэд үйлчлэх нэгдсэн төвтэй болгосон.</p> <p>➤ Мөн нийт 164 сумын ахуйн үйлчилгээний төвд хөрөнгө оруулалт хийж одоогоор нийт 221 төв үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.</p> <p>➤ Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд нийт 3444 ажлын байр шинээр бий болж 431 ажлын байр сургалт семинарын явцад, 3013 ажлын байр ЖДҮХСан, Сум хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан болон бусад хэрэгжсэн төслийн хүрээнд бий болсон байна. Оноор нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> • 2014 онд 2218 ажлын байр, • 2015 оны 684 ажлын байр, • 2016 онд 542 ажлын байр тус тус бий болсон байна. <p>➤ Хөтөлбөрийн санхүүжилтэнд төсөвлөсөн 12 тэрбум төгрөгнөөс тодорхой бусад шалтгаануудаас үүдэн 5.6 тербум төгрөгийн санхүүжилтийг олгоогүйгээс 109 сумдад шинээр болон засварлан шинэчлэх 109 ахуйн үйлчилгээний төвийг барьж чадаагүй байна.</p> <p>➤ Хөтөлбөрийн хүрээнд маш олон ажил хийгдсэн боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудал нь бүтэцийн өөрчлөлтөөр байнга солигдож хийсэн ажил үнэгүйдэх, мэдээлэл нь олдохгүй байх зэргээс шалтгаалан тайланд бүрэн тусгагдаагүйгээс хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн түвшинд үнэлгээ хийх боломжгүй байна.</p>																																				
8.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилт1	Зорилт2	Зорилт3	Зорилт4																																
	Хувиар	80.8	90.0	86.6	70.0	76.6																																
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ																																				
		... %																																				